

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцох
нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлыг тайланг хянаж, нийтэд мэдээлэх

АУДИТЫН КОД: ТӨА-2025/120/ШТА-НА

Зуунмод 2025

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Ахлах аудитор Т.Хүрэлбаатар
Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatar@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1. Аудитын нэр

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлыг тайланг хянаж, нийтэд мэдээлэх

2. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заасныг үндэслэн Төв аймаг дахь Төрийн аудитын газар нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд нийцлийн аудит хийлээ.

3. Аудитын зорилго

Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлнэ.

4. Аудитын хамрах хүрээ

Аудитад Төв аймгийн Заамар, Лүн, Өндөрширээт, Угтаалцайдам, Эрдэнэ, Эрдэнэсант сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд өгсөн хараат бус хуулийн этгээдийн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлан, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамруулав.

5. Арга зүй

Аудитын ажлыг гүйцэтгэхэд Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заасныг үндэслэлээ.

Нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө, нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив, түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвсэл, нэр дэвшигчдээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

6. Үндсэн мэдээлэл

Төв аймгийн Заамар, Лүн, Өндөрширээт, Угтаалцайдам, Эрдэнэ, Эрдэнэсант сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд 2 намын 7 нэр дэвшигч, бие даан 1 нэр дэвшигч, нийт 8 нэр дэвшигч оролцсон байна.

Хүснэгт №1

Сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн тоо /намаар/

Д/д	Нам, эвсэлийн нэр	Нам	Бие даан нэр дэвшигч	Нэр дэвшигчид
1	Монгол Ардын Нам	6		6
2	Ардчилсан нам	1		1
3	Бие даан нэр дэвшигч		1	1
Дүн		7	1	8

Эх сурвалж: Нэр дэвшигчдийн зардлын тайлан

Төв аймгийн Заамар, Лүн, Өндөрширээт, Угтаалцайдам, Эрдэнэ, Эрдэнэсант сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд нэр дэвшсэн 8 нэр дэвшигчдээс Угтаалцайдам, Эрдэнэ сумдын 3 нэр дэвшигч Төрийн аудитын газарт сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй байна. Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн зардлын хураангуй тайлангаар нэр дэвшигчдийн дансанд орлого зарлагын гүйлгээ хийгдээгүй, харилцах дансанд үлдэгдэлгүй тайлагнасан байна.

7. Сонгуулийн зардлын тайлан

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу тайлангаа ирүүлбэл зохих 8 нэр дэвшигчээс Монгол ардын намын 5 нэр дэвшигч тайлангаа ирүүлж, Монгол ардын намын 1, Ардчилсан намын 1, бие даасан 1 нэр дэвшигч, нийт 3 нэр дэвшигч тайлангаа ирүүлээгүй байна.

Хүснэгт №2

Зардлын тайлангаа ирүүлээгүй нэр дэвшигчдийн тоо /намаар/

Д/д	Нам, эвсэлийн нэр	Нам	Бие даан нэр дэвшигч	Нэр дэвшигчид
1	Монгол Ардын Нам	1		1
2	Ардчилсан нам	1		1
3	Бие даан нэр дэвшигч		1	1
Дүн		2	1	3

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-д “Нам, эвсэл болон нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх

үүрэгтэй” гэж заасны дагуу дансны дугаар, банкны нэрийг хугацаанд нь бүртгүүлсэн 1 нэр дэвшигч, бүртгүүлээгүй 7 нэр дэвшигч байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.4-д “Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, иргэний бүртгэлийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй буюу хувийн дансандаа хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг хүлээн авч буцаалгүй зарцуулсан 1 нэр дэвшигч байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-д “Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээгээний бүх хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны хуулгыг ХААН банк, Төрийн банкнаас нэр дэвшигчийн тайланд хавсарган ирүүлсэн байна.

8.Аудитын дүгнэлт

Төв аймгийн Заамар, Лүн, Өндөрширээт, Угтаалцайдам, Эрдэнэ, Эрдэнэсант сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 8 нэр дэвшигчээс хуулийн хугацаанд ирүүлсэн сонгуулийн зардлын 5 тайланг хянаж үзэхэд 5 нэр дэвшигч нь хандив аваагүй, сонгуулийн зардлын тайланг үнэн зөв гаргаж, хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулж ирүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн заасны дагуу Төрийн аудитын газарт сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй 3 нэр дэвшигч, сонгуулийн зардлын дансны мэдээллийг бүртгүүлээгүй 7 нэр дэвшигч, хуулиар зөвшөөрөөгүй хандивыг улсын төсөвт буцаан төвлөрүүлээгүй 1 нэр дэвшигчийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.12-т “татварын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн ..., 17.1 дүгээр зүйлийн 21, 23 дахь хэсэгт заасан зөрчил” гэсэн заалтыг үндэслэн аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Татварын газарт шийдвэрлүүлэхээр хүргүүллээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заасан бөгөөд Төв аймгийн Заамар, Лүн, Өндөрширээт, Угтаалцайдам, Эрдэнэ, Эрдэнэсант сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцож зардлын тайлангаа ирүүлсэн 5 нэр дэвшигч нь дээрх хуульд заасан хэмжээнээс дээш төгрөгийн хандив аваагүй байна.

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2025.08.28

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчдээс сонгуулийн хандивын зардлын дансыг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт бүртгүүлээгүй нэр дэвшигчдийн жагсаалт

№	Нэр дэвшигчийн эцэг /эх/ ийн нэр, өөрийн нэр	Нэр дэвшсэн Аймаг, Дүүрэг, Сум	Нэр дэвшүүлсэн нам эвслийн нэр
1	Ч.Баяндалай	Төв аймгийн Заамар сум	Монгол ардын нам
2	Б.Оюунтуяа	Төв аймгийн Лүн сум	Монгол ардын нам
3	С.Батмөнх	Төв аймгийн Өндөрширээт сум	Монгол ардын нам
4	М.Урантогос	Төв аймгийн Угтаалцайдам сум	Монгол ардын нам
5	Ч.Лхагвадулам	Төв аймгийн Эрдэнэ сум	Ардчилсан нам
6	А.Золзаяа	Төв аймгийн Эрдэнэ сум	Бие даан нэр дэвшигч
7	Б.Мөнхбилэгтэй	Төв аймгийн Эрдэнэсант сум	Монгол ардын нам

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон хандивын зардлын тайлан ирүүлээгүй нэр дэвшигчид

№	Нэр дэвшигчийн эцэг /эх/ ийн нэр, өөрийн нэр	Нэр дэвшсэн Аймаг, Дүүрэг, Сум	Нэр дэвшүүлсэн нам эвслийн нэр
1	М.Урантогос	Төв аймгийн Угтаалцайдам сум	Монгол ардын нам
2	Ч.Лхагвадулам	Төв аймгийн Эрдэнэ сум	Ардчилсан нам
3	А.Золзаяа	Төв аймгийн Эрдэнэ сум	Бие даан нэр дэвшигч

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн хуулиар зөвшөөрөөгүй буцаах хандив

№	Нэр дэвшигчийн эцэг /эх/ ийн нэр, өөрийн нэр	Нэр дэвшсэн Аймаг, Дүүрэг, Сум	Нэр дэвшүүлсэн нам эвслийн нэр	Хуулиар зөвшөөрөгдөөгүй буцаах хандив
1	Б.Мөнхбилэгтэй	Төв аймгийн Эрдэнэсант сум	Монгол ардын нам	500,000
Нийт дүн				500,000